

Үндэсний хөгжлийн газрын даргын
2018 оны 06 сарын 18 өдрийн 15-оор
тушаалын хавсралт

ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН УРЬДЧИЛСАН СУДАЛГАА ХИЙХ АРГАЧЛАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

УХА0588
6098177
1116127253

- 1.1 Засгийн газрын 2018 оны 348 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасныг тус тус үндэслэн “Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх аргачлал”-ыг боловсруулав.
- 1.2 Энэхүү аргачлал нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /цаашид УХОХ/-ийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад чиглэгдэх бөгөөд төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааны хамрах хүрээ, бүтэц, агуулгыг нийтлэг байдлаар тодорхойлох зорилготой.
- 1.3 Төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь Суурь судалгаа, Техник эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах, Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах гэсэн үндсэн 3 үе шатанд хуваагдах ба энэхүү аргачлал нь хоёр дахь үе шат буюу ТЭЗУС боловсруулахад ашиглагдана.
- 1.4 Техник эдийн засгийн урьдчилсан судалгаа нь төслийн суурь судалгаанд үндэслэх ба техник эдийн засгийн үндэслэл боловсруулах үндэслэл болно.
- 1.5 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар санал болгож буй хөрөнгө оруулалтын төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг энэ аргачлалын дагуу гүйцэтгэх ба энд тусгагдсан мэдээлэл нь уг төсөл, арга хэмжээг (цаашид төсөл гэх) үнэлэх, эрэмбэлэх, сонгоход ашиглагдана.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.
Үүнд:
 - *Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр* - Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийн хэлнэ.
 - *Төслийн зорилт* - Асуудлыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэхэд чиглэсэн, оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц эерэг өөрчлөлт.
 - *Төслийн үр нөлөө* - Тухайн төслийг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны хүрээнд бий болох өөрчлөлтийг;
 - *Бүтээгдэхүүн, үйлчилгээ* - Төслийг хэрэгжүүлсний үр дүнд төслийн үр шимийг хүртэгчдэд нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээг;
 - *Суурь судалгаа хийх үе шатанд төсөл хэрэгжих орчин, нийгэм эдийн засгийн өнөөгийн байдлын суурь судалгаа, төслийн хэрэгцээ, шаардлага, үндэслэл, төслөөр шийдвэрлэх асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн өөрийн орны болон гадаад орнуудын туршлага болон төслийн үндсэн шийдлүүдийн суурь судалгааг хийн, төслийн хэрэгжих боломжтой эсэхийг урьдчилсан байдлаар тодорхойлж, техник эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгаа хийх буюу төсөл хөгжүүлэлтийн дараагийн шатанд шилжих эсэх дүгнэлтийг гаргана.*

- *Техник эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах* үе шатанд төслийн хэрэгцээ, шаардлага, төслийн нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдал, зардал, үр ашиг, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход чиглэсэн судалгаа хийх шаардлагатай бөгөөд төслийг цаашид нарийвчлан судлах, хэрэгжүүлэх боломжтой эсэх, хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргах үндэслэл болно.
- *Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах* үе шатанд төслийг хэрэгжүүлэх хөгжлийн хэрэгцээ, нийгэм эдийн засгийн үндэслэл, хууль эрх зүйн орчин, зах зээл, хүний нөөцийн чадавх, дэд бүтцийн хүчин чадал, хангамж зэргийг нарийвчлан судалж, техник технологийн шийдэл, хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдал, байр талбайн хэрэгцээнд тулгуурлан төслийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцоолж, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, ажиллах хүч, түүхий эд, зардлын хэмжээ, олох ашиг, санхүү үр ашгийн тооцоо, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, эдийн засгийн шинжилгээ, байгаль орчны төлөв байдлын шинжилгээ, инженер геологийн судалгаа зэрэг нарийвчлсан судалгаануудыг хийн төслийг хэрэгжүүлэх хувилбаруудыг тодорхойлно.

ГУРАВ. ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН УРЬДЧИЛСАН СУДАЛГААГ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1 Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа нь нарийвчилсан судалгаа хийх, төслийг хэрэгжүүлэх эсэх талаар оновчтой шийдвэр гаргахад чиглэгдсэн байх ба үнэн зөв, бодитой мэдээ, мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэгдсэн байна.
- 3.2 Энэхүү аргачлал нь хөрөнгө оруулалтын төслийн ТЭЗУС-ны хамрах хүрээ, бүтэц, агуулгын талаарх нийтлэг ойлголтын хүрээнд ерөнхий байдлаар боловсруулагдсан тул тухайн төслийн онцлогт тохируулан холбогдох өөрчлөлтийг хийж хэрэглэнэ.
- 3.3 ТЭЗУС боловсруулах судалгааны баг нь төслийн онцлогоос хамааран хэдэн ч судлаачийн бүрэлдэхүүнтэй байж болох ч дор хаяж тухайн төсөл хэрэгжих салбарын технологи, удирдлага зохион байгуулалт, санхүү хөрөнгө оруулалт, эрсдэлийн чиглэлийн мэргэжилтнүүдтэй байвал зохино.

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН УРЬДЧИЛСАН СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, АГУУЛГА

- 4.1. Техник эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах ажлын хамрах хүрээ нь тухайн хөрөнгө оруулалтын төслийн онцлогоос хамааран харилцан адилгүй байх боловч дараах нийтлэг агуулгатай байна. Үүнд:

4.1.1. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

4.1.1.1. Макро эдийн засгийн өнөөгийн байдлын шинжилгээ

ДНБ, эдийн засгийн өсөлт, төсөл хэрэгжих салбарын ДНБ-д эзлэх хувь, түүний динамикийн шинжилгээ, валютын ханш, инфляцийн түвшин, зээлийн хүүгийн динамикийн шинжилгээ, түүний төсөлд үзүүлэх нөлөөлөл, гадаад худалдааны тэнцэл, экспорт, импортын динамикийн шинжилгээ, төсөл хэрэгжих салбарын экспорт, импорт, тэдгээрийн гадаад худалдааны тэнцэлд үзүүлж буй нөлөөлөл, улсын төсөвтэй хамааралтай төсөл бол улсын төсвийн орлого, зарлага, төсөл хэрэгжих салбарын эзэлж буй хувь, нөлөөлөх нөлөөлөл г.м. макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж, төсөлд/төслийн үзүүлэх нөлөөллийг урьдчилсан байдлаар томъёолно.

4.1.1.2. Хүн ам зүйн судалгаа

Хүн амын тоо, өсөлт, нягтрал, нас, хүйсийн бүтэц, байршил, шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдал, хэтийн төлөв, хүн амын дундаж наслалт, амьдралын чанар, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, боловсролын түвшин, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, өрхийн орлого, зарлага, иргэдийн ажил эрхлэлт, ядуурлын түвшин зэрэг хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж, төсөлд/төслийн үзүүлэх нөлөөллийг урьдчилсан байдлаар томъёолно.

4.1.1.3. Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын өнөөгийн байдлын шинжилгээ

Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын хөгжлийн түвшин, үр дүн, нөхцөл байдлыг тодорхойлдог үндсэн суурь үзүүлэлтүүд ямар байгаа, тэдгээрийг урт, дунд, богино хугацаандаа хэрхэн өөрчлөх зорилтыг засгийн газраас дэвшүүлсэн болох, тэдгээр зорилтоо хангах үүднээс авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд, тэдгээрийн явц, үр дүн ямар байгаа зэргийг тодорхойлно. Ингэж тодорхойлохдоо энэхүү төсөлтэй уялдах үзүүлэлтүүд, зорилго, зорилт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг авч үзнэ.

а. Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын өнөөгийн байдлын судалгаа

- Төсөл хэрэгжих салбарын институцын тогтолцоо, хүчин чадал, хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, санхүүгийн гэх мэт салбарын чадавхын суурь судалгааг хийнэ. Энд төсөл хэрэгжих дэд салбарын нөхцөл байдлын үзүүлэлтүүдийг илүү дэлгэрэнгүй авч үзнэ.
- Төсөл хэрэгжих салбарын улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлж буй хувь нэмэр, үйл ажиллагаа, үр дүнг хэмжих үндсэн үзүүлэлтүүдийн 5-с доошгүй жилийн динамикийн шинжилгээ г.м.
- Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын олон улсын болон манай улсын техник, технологийн хөгжлийн өнөөгийн байдал, хүрсэн түвшин, хөгжлийн цаашдын чиг хандлага

б. Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын бодлогын судалгаа

- Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын тулгамдаж буй асуудлууд, хэрэгцээ шаардлага, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэгдсэн бодлого, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилтууд, энэ төслийг хэрэгжүүлснээр ямар зорилтыг хэрхэн хангахыг тодорхойлно.
- Төсөл хэрэгжих салбар, дэд салбарт дэвшүүлсэн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн ямар төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрхэн хэрэгжсэн, хэрэгжиж буй, цаашид ямар төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж буйг тэдгээртэй энэхүү төсөл нь хэрхэн уялдах уялдаа тодорхойлно.

4.1.1.4. Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн өнөөгийн байдлын шинжилгээ

Энэхүү судалгаа нь төсөл хэрэгжих, төслийн үр шимийг хүртэх бүс орон нутгийн хэмжээнд хийгдэх ба хэрэв тухайн төсөл нь улсын хэмжээнд хэрэгжих эсхүл үр шимийг хүртэгсэд нь монгол улсын нийт иргэд бол өмнөх бүлгүүдийн судалгааг дэлгэрүүлэн хийж энэ бүлэгт хамаарах судалгааг хийхгүй байж болно.

а. Ерөнхий мэдээлэл

- Төсөл хэрэгжих, төслийн үр шимийг хүртэх бүс, орон нутгийн газарзүй, байршил, байгаль, цаг уур, хүн ам, түүх, соёл г.м. тухайн орон нутгийн талаарх суурь судалгааг хийнэ.

б. Төсөл хэрэгжих, төслийн үр шимийг хүртэх бүс, орон нутгийн хөгжил

- Тухайн бүс, орон нутгийн хүн амын тоо, өсөлт, нягтрал, нас, хүйсийн бүтэц, байршил, шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдал, хэтийн төлөв, хүн амын дундаж наслалт, амьдралын чанар, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс

- Өрхийн орлого, зарлага, иргэдийн ажил эрхлэлт, ядуурлын түвшин, боловсролын түвшин
- Тухайн бүс, орон нутгийн эдийн засаг, бизнесийн хөгжлийн өнөөгийн байдал, хэтийн чиг хандлага

в. Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын тухайн бүс, орон нутаг дах хөгжил

- Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын тухайн бүс, орон нутаг дах хүчин чадал, хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, санхүүгийн гэх мэт салбарын чадавхын суурь судалгааг хийнэ. Энд төсөл хэрэгжих дэд салбарын нөхцөл байдлын үзүүлэлтүүдийг илүү дэлгэрэнгүй авч үзнэ.
- Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын тухайн бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлж буй хувь нэмэр, үйл ажиллагаа, үр дүнг хэмжих үндсэн үзүүлэлтүүдийн 5-с доошгүй жилийн динамикийн шинжилгээ г.м.

4.1.1.5. Хууль эрх зүйн орчны шинжилгээ

Энэ хэсэгт төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, журам, дүрэм, тогтоол, шийдвэрүүд, холбогдох тусгай зөвшөөрөл, лиценз, дэмжих болон хязгаарлах зохицуулалтууд, төслөөр хэрэгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ болон төслийн хүрээнд хийгдэх ажлуудад тавигдах шаардлага, стандартуудыг тодорхойлно.

4.1.1.6. Төслийн онцлогоос хамааран хийгдэх нэмэлт судалгаа, шинжилгээнүүд
Тухайн төслийн онцлогоос хамааран энд тусгагдаагүй бусад судалгаа, шинжилгээнүүдийг хийж болно.

4.1.2. ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШИНЖИЛГЭЭ

4.1.2.1. Эрэлтийн шинжилгээ

Энэ хэсэгт төслийн үр шимийг хүртэгчид, зорилтот хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн сегментийг төлөвлөж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл тус бүрээр тодорхойлон, тэдгээрийн бодит эрэлт хэрэгцээ, шаардлагыг тодруулна. Мөн уг төслийг хэрэгжүүлснээр эрх ашиг нь хөндөгдөх бусад талууд буюу оролцогчдын судалгааг хийж, тэдгээрт нөлөөлөх эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлно.

4.1.2.2. Нийлүүлэлтийн шинжилгээ

Энэ хэсэгт төлөвлөж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээтэй ижил эсхүл төстэй бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрт ашиглагдах түүхий эд, материалын нийлүүлэлт, хангамжийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, ижил эсхүл төстэй үйл ажиллагаа явуулагчдын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, хүчин чадал болон хүний нөөц, техник тоног төхөөрөмж зэрэг чадавхын судалгааг хийж, тэдгээрийн давуу сул талыг тодорхойлно. Хэрэв тухайн бүс, орон нутагт болон улсын хэмжээнд ижил эсхүл төстэй үйл ажиллагаа явуулагч байхгүй бол төслийн зорилтот зах зээл, зах зээлийн багтаамжийг тодорхойлох үүднээс одоо хэрэгжиж байгаа, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг судлах шаардлагатай.

4.1.2.3. Зөрүүгийн (GAP) шинжилгээ

Энэ хэсэгт эрэлтийн болон нийлүүлэлтийн шинжилгээний үр дүнд үндэслэн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүгийн (GAP) шинжилгээг хийж, төслөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээ, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, зах зээлийн сегмент, багтаамж зэргийг тодорхойлно.

4.1.2.4. Төслийн онцлогоос хамааран хийгдэх нэмэлт судалгаа, шинжилгээнүүд
Тухайн төслийн онцлогоос хамааран энд тусгагдаагүй бусад судалгаа, шинжилгээнүүдийг хийж болно.

4.1.3. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэ хэсэгт төслийн зорилго, зорилт буюу төслөөр шийдвэрлэх асуудал, хүлээгдэж буй үр дүн, төслийг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засаг, төслийн үр шимийг хүртэгчдэд ямар эерэг өөрчлөлт гарахыг тодорхойлно. Энэхүү эерэг өөрчлөлт буюу төслийн хүлээгдэж буй үр дүнг зорилго гэх бол зорилт нь хэрхэн яаж, ямар шат дараалалтайгаар төслийн зорилгод хүрэхийг тусгасан тодорхой цаг хугацаанд төлөвлөгдсөн, хүрч болохуйц үр дүнг хэлнэ. Өөрөөр хэлбэл, төслийн зорилт нь төслөөр дэвшүүлсэн зорилгодоо хэрхэн хүрэх үйл ажиллагааны хамрах хүрээг илэрхийлнэ. Төслийн зорилго, зорилт нь тодорхой, оновчтой (S), хэмжиж болохуйц (M), хүрч болохуйц (A), хэрэгжихүйц бодитой (R), тодорхой хугацаанд төлөвлөгдсөн (T) байна.

4.1.3.1. Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, үндэслэл

Өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээний үр дүнд үндэслэн төслийг хэрэгжүүлэх ямар зайлшгүй хэрэгцээ шаардлага байгааг, хэрэгжүүлэх үндэслэл байгаа эсэх, хэрэгжүүлснээр ямар асуудлыг шийдвэрлэхийг тодорхойлно.

4.1.3.2. Төслийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

Төслөөр шийдвэрлэх асуудал буюу төслийн нэг ерөнхий зорилго, хүрэх үр дүнг тэрхүү үр дүндээ хүрсэн эсэхийг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт SMART зарчмыг баримтлан тодорхойлно. Төслөөр дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд төсөл хэрэгжүүлэх үе шат бүрийн хүрэх үр дүн буюу зорилтуудыг, тэрхүү үр дүндээ хүрсэн эсэхийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн хамт SMART зарчмыг баримтлан тодорхойлно. Тэдгээр зорилтуудыг тодорхойлохдоо хэрэгжилтийн төвөгшлийн түвшнээр, цаашид хэрэгжих магадлал, эрсдэлийн түвшнийг үнэлэх боломжтой байдлаар ангилсан байна. Төслийн зорилго, зорилт тус бүрээр шалгуур үзүүлэлтүүдийн одоогийн суурь түвшин болон төсөл хэрэгжсэнээр хүрэх зорилтот түвшнийг заавал тодорхойлох бөгөөд энэ нь суурь түвшнийг зорилтот түвшинтэй харьцуулан төслийг хэрэгжүүлснээр ямар эерэг өөрчлөлт бий болсныг дүгнэх боломжийг бүрдүүлнэ.

4.1.3.3. Төслийн амжилтын хүчин зүйлс, нийгэм, эдийн засгийн үр нөлөө

Төслийг амжилттай хэрэгжүүлж, зорилгодоо хүрэхэд нөлөөлөх амжилтын хүчин зүйлсийг тодорхойлж, хүчин зүйл нэг бүрээр шинжилгээ хийнэ. Түүнчлэн төслөөр дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа хэрэгжүүлснээр улс, бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, хүрээлэн буй орчин, төсөл хэрэгжих салбар, дэд салбарын хөгжилд ямар үр нөлөө үзүүлэхийг зорилт тус бүрийн хувьд 2-оос доошгүй үзүүлэлтээр, мөн төслийн үр шимийг хүртэгчдэд хэрхэн нөлөөлөх, тэдэнд ямар эерэг өөрчлөлтүүд гарахыг тайлбарлана.

4.1.4. ТӨСЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

Энэ хэсэг нь төслийн зах зээлийн боломж, төслийн хүрээнд санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, шинж чанар, хүчин чадлыг (хэмжих нэгж нь эрэлтийг тодорхойлсон нэгж байна), төлөвлөсөн нарийвчилсан төлөвлөгөөг багтаана. Мөн үйл ажиллагааны технологи, дараалал, зохион байгуулалт, тэдгээрийн барилга байгууламж, ажлын талбайн зохион байгуулалт, хуваарилалттай уялдах уялдаа зэрэг төслийн технологи, зохион байгуулалтын талаарх ерөнхий мэдээллийг танилцуулна.

4.1.4.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхойлолт

Төслийн хүрээнд төлөвлөж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн нэр төрөл, шинж чанар, онцлог, хүчин чадал, үнэ тариф зэргийг зорилтот зах зээл тус бүрийн хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээ нэг бүрээр эсхүл бүтээгдэхүүн үйлчилгээний ангилал тус бүрээр тодорхойлон, тэдгээрийн зах зээлийн боломж, ямар асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг тайлбарлана.

4.1.4.2. Техник, технологийн шийдэл

Төслийн техник, технологийн харьцуулалт, сонголт, шийдэлтэй холбоотой тооцоо, судалгааг хийнэ. Мөн технологийн процесс, түүний барилга байгууламж, ажлын талбайн

зохион байгуулалт, хуваарилалттай уялдах уялдаа зэргийг бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл тус бүрээр эсхүл ангилал тус бүрээр тодорхойлно.

4.1.4.3. Төслийн онцлогоос хамааран хийгдэх бусад шийдлүүд

Тухайн төслийн онцлогоос хамааран дээр дурдаагүй бусад холбогдох шийдлүүдийг тодорхойлно.

4.1.5. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ

4.1.5.1. Архитектур төлөвлөлтийн шийдэл

Энэ хэсэгт барилга байгууламжийн төлөвлөлтөд баримтлах зарчим, төлөвлөлтийн үндсэн шийдэл, барилга байгууламжийн бүрэлдэхүүн, бүтэц, хүчин чадал, хэмжээ, төсөв зэргийг боловсруулан танилцуулна. Ингэж төлөвлөхдөө олон улсын хөгжлийн чиг хандлага болон барилга, байгууламжид тавигдах үндсэн шаардлага, норм дүрэм, стандартад нийцүүлсэн байвал зохино.

4.1.5.2. Дэд бүтцийн төлөвлөлт

Дэд бүтцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, дэд бүтцийн суурь нөхцөл, хүрэлцээ, хангамжийн өнөөгийн байдлыг тодорхойлох судалгаануудыг дэд бүтэц тус бүрээр хийж, үр дүнд үндэслэн дэд бүтцийн үндсэн шийдэл, хүчин чадал, хэмжээ, төсөв, тавигдах шаардлага, баримтлах зарчим зэргийг багтаасан төлөвлөлтийг хийнэ.

4.1.5.3. Төслийн онцлогоос хамааран хийгдэх бусад шийдлүүд

Тухайн төслийн онцлогоос хамааран дээр дурдаагүй бусад холбогдох шийдлүүдийг тодорхойлно.

4.1.6. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ хэсэгт төслийн техник технологийн шийдэлд үндэслэсэн хэрэгжүүлэх арга хэмжээ, гүйцэтгэх ажил, хугацаа, удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн төлөвлөлтийг төслийн хөгжүүлэлт, хэрэгжилтийн үе шат тус бүрээр (төлөвлөлтийн буюу бэлтгэл үе шат, бүтээн байгуулалтын үе шат, барилга байгууламж ашиглалтад орсноос хойш үйл ажиллагаа жигдрэх хүртэлх үе шат) хийнэ.

4.1.6.1. Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн төлөвлөлт

Төслийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт ямар байх, зохион байгуулалтын нэгж тус бүрийн гүйцэтгэх үндсэн чиг үүрэг юу байх, тэдгээрт шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг төслийн хэрэгжилтийн үе шат, хугацаа, үйл ажиллагааны чиглэл тус бүрээр тодорхойлсон хүний нөөцийн хэрэгцээний төлөвлөгөөг урьдчилсан байдлаар боловсруулна. Энэхүү төлөвлөгөөндөө үндэслэн шаардлагатай хүний нөөцийг хэрхэн бүрдүүлэх хүний нөөцийн хангалтын төлөвлөгөөг боловсруулна.

4.1.6.2. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт

Төслийн хөгжүүлэлт, хэрэгжилтийн үе шат (төлөвлөлтийн буюу бэлтгэл үе шат, бүтээн байгуулалтын үе шат, барилга байгууламж ашиглалтад орсноос хойш үйл ажиллагаа жигдрэх хүртэлх үе шат) болон төслөөр дэвшүүлсэн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл тус бүрээр хэрэгжүүлэх арга хэмжээ, гүйцэтгэх ажлуудыг тодорхойлно. Эдгээр ажил тус бүрээр тэдгээрийг гүйцэтгэх хугацаа, зохион байгуулалт, шаардагдах нөөцүүд (хүний, материал, санхүү, мэдээллийн г.м), хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага, нөхцөл, тохиолдож болох саад бэрхшээл, эрсдэл, явц ү дүнг хянах тогтолцоо зэргийг тусгасан төлөвлөгөө боловсруулна.

4.1.6.3. Төслийн онцлогоос хамааран хийгдэх нэмэлт төлөвлөлтүүд

Тухайн төслийн онцлогоос хамааран энд дурдаагүй өөр төлөвлөлтүүд хийгдэж болно.

4.1.7. ТӨСЛИЙН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО

Энэ хэсэгт төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, үйл ажиллагаа хэвийн явагдах үеийн зардал, орлогыг тооцоолон санхүүжилтийн эх үүсвэрийн /улсын төсөв, гадаадын зээл, тусламж, концесс, төр хувийн хэвшлийн түншлэл, хөгжлийн банкны санхүүжилт, шууд хөрөнгө оруулалт г.м./ боломжит хувилбарыг санал болгоно.

4.1.7.1. Төслийн анхны хөрөнгө оруулалтын тооцоо

Анхны хөрөнгө оруулалт нь үндсэн хөрөнгө (биет, биет бус хөрөнгө), эргэлтийн хөрөнгө, төслийн бэлтгэл ажиллагааны дараах зардлаас бүрдэнэ. Үүнд:

- *Төлөвлөлт, бэлтгэл үйл ажиллагаатай холбоотой зардлууд* – суурь судалгаа, ТЭЗУС, ТЭЗҮ, дизайн, төлөвлөлт, зураг төсөв, инженерийн судалгаанууд, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон бусад холбогдох судалгаа, төлөвлөлтийн зардлууд, энэ үе шатны санхүүжилтийн өртөг, түүнтэй холбоотой гарсан томилолт, цалин гэх мэт үйл ажиллагаа, удирдлагын бүх зардлууд, боловсон хүчин бэлтгэх, бүтээн байгуулалтын үеийн даатгал, төслийг эхлүүлэхтэй холбоотой эрх зүйн туслалцаа авах, бичиг баримт бүрдүүлэхтэй холбоотой эрх зүйн төлбөр г.м. зардлуудыг оруулан тооцно.
- *Барилга, байгууламжтай холбоотой зардлууд* – газар худалдан авах, газрын нөхөн төлбөр төлөх, газар чөлөөлөлттэй холбоотой зардлууд, барилга байгууламжийг барих зардлыг төлөвлөлтийн шийдэл болон холбогдох норм дүрэм, стандартын дагуу урьдчилсан байдлаар тооцно.
- *Дэд бүтэцтэй холбоотой зардлууд* – ус, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, мэдээлэл холбоо гэх мэт дэд бүтцийг шинээр байгуулах, шинэчлэн сайжруулах, өргөтгөх, засварлахтай холбоотой зардлуудыг дэд бүтцийн төлөвлөлт, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм дүрэм, стандартын дагуу урьдчилсан байдлаар тооцно.
- *Машин, техник, тоног төхөөрөмжтэй холбоотой зардлууд* - тоног төхөөрөмж, техник хэрэгслийг худалдан авах үнэ, захиалга, нийлүүлэлт, тээвэрлэлт, угсралт, сургалтын гэх мэт захиалга хийхээс суурилуулж ашиглах хүртэлх зардлыг нэмсэн дүнгээр тооцно.
- *Тээврийн хэрэгсэл, компьютер, бусад хэрэгсэл, тавилга, эд хогшил*: худалдан авах үнэ дээр суурилуулж ашиглах хүртэлх зардлыг нэмсэн дүнгээр тооцно.
- *Биет бус хөрөнгө*: Төслийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тусгай зөвшөөрөл, зохиогчийн эрх, программ хангамж, патент зэргийг үүнд оруулан тооцно.
- *Санхүүжилтийн өртөг*: Анхны хөрөнгө оруулалттай холбогдон гарсан зээл, бондын хүүгийн зардлыг оруулан тооцож болно.
- *Эргэлтийн хөрөнгийн зардал* - Барилга, байгууламж ашиглалтад орсноос хойших шилжилтийн үеийн 6 хүртэлх сар, үйл ажиллагаа эхэлснээс хойших эхний 12 хүртэлх сарын үйл ажиллагааны зардлын санхүүжилтыг хөрөнгө оруулалтын зардалд оруулан тооцно.
- Хэрэв төслийн хөрөнгө оруулалтад өөрсдийн өмнө ашиглаж байсан хөрөнгө болон бусдаас авсан хуучин эд хөрөнгийг ашиглах бол үлдэгдэл өртгөөр тооцон хөрөнгө оруулалтын зардалд оруулах ба тэдгээрийг тээвэрлэх, сэргээн засварлах, суурилуулахтай холбоотой бүхий л зардлууд орно.
- Хэрэв одоо үйл ажиллагаагаа явуулж байгаа бол бүтээн байгуулалтын ажлууд дуусч, шинэ барьсан, өргөтгөсөн эсхүл засварласан барилга, байгууламжууд ашиглалтад орох хүртэл гарах түр дэд бүтцийн ашиглалт, нүүлгэн шилжүүлэлт, үйл ажиллагаагаа түр явуулахтай холбоотой зардлууд, мөн өөрчлөлтийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой ажилтнуудын шинэ тоног төхөөрөмжийн сургалт, нээлтийн

сурталчилгаа, танилцуулга, хэвлэл, тохижилт, арга хэмжээний г.м. зардлууд /transfer and change management cost/

4.1.7.2. Төслийн санхүүгийн тооцоолол

- **Зардал:** Төслийн барилга, байгууламж ашиглалтад орсноос хойших нийт зардлаар жил бүрээр таамаглах ба тодорхой үеүдээр үечилсэн байдлаар шинэчилж тооцож болно. Төслийн онцлогоос хамааран зардлын бүтэц нь ялгаатай байх боловч хүний нөөцтэй холбоотой зардал, түүхий эд, материалын зардал, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн зардал, ашиглалтын зардал, маркетинг зар сурталчилгааны зардал, тээвэр, холбоо, бичиг хэрэг, элэгдэл, хорогдлын шимтгэлийн зардлууд, үйл ажиллагааны санхүүжилтийн өртөг буюу зээл, бондын хүүгийн зардал зэрэг нийтлэг зардлууд багтана. Хүний нөөцтэй холбоотой зардал гэдэгт цалин, урамшуулал, даатгал, нэмэгдэл хангамж, хувь хүний сургалт, мэргэжил дээшлүүлэлт, тэтгэмж тусламжийн зардлуудыг хамруулна. Хэрэв одоогийн үйл ажиллагааг сайжруулж, шинэчилж байвал одоогийн гарч байгаа зардлыг төслийн эхний жилийн зардалд оруулж тооцох нь зүйтэй.
- **Орлого:** Төслийн барилга, байгууламж ашиглалтад орсноос хойших үйл ажиллагааны орлогоор орлогын тооцооллыг хийнэ. Төслийн онцлогоос хамааран орлогын бүтэц нь ялгаатай байх боловч үйл ажиллагааны орлогод борлуулалтын орлого, үйлчилгээ үзүүлсний орлого г.м. үндсэн үйл ажиллагааны дагуу орлого, үндсэн бус үйл ажиллагааны орлогод үндсэн үйл ажиллагаанаас бусад төрлөөр үйл ажиллагаа явуулан олсон орлого, хандив тусламж гэх мэт орлогууд багтана. Орлогын таамаглалыг ашиглалтын хүчин чадал, зах зээлийн ирээдүйн төлөв байдлаас хамааруулан шууд тооцооллын арга /тогтоосон үнээр шууд тооцох/, ижил төстэй үйл ажиллагаа явуулагчтай харьцуулсан тооцоолол, өнгөрсөн хугацаанд олж байсан орлогыг хүчин чадлын өсөлтийн хэмжээгээр өсгөж тооцох зэрэг аргуудаар он тус бүрээр хийнэ.

4.1.7.3. Санхүүжилтийн эх үүсвэр, хуваарь

Төслийг ямар эх үүсвэрээр хэрхэн санхүүжүүлэх санхүүжилтийн хуваарийг боловсруулж, боломжит эх үүсвэрийн талаарх саналаа гарган, тэрхүү эх үүсвэрийг яагаад сонгосон болох, төсөл нь тухайн эх үүсвэрийн тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхой тайлбарлана.

4.1.8. ТӨСЛИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ

Энэ хэсэгт анхны хөрөнгө оруулалтын болон санхүүгийн орлого, зарлагын тооцооллууддаа үндэслэн санхүү болон эдийн засгийн үр ашгийн шинжилгээг хийнэ. Энэ нь тухайн төсөл санхүүгийн болон/эсхүл эдийн засгийн хувьд үндэслэлтэй, хэрэгжих боломжтой, ашигтай эсэхийг тодорхойлно.

4.1.8.1. Санхүү, хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ

Энэ хэсэгт өмнө хийгдсэн санхүүгийн тооцоололд үндэслэн санхүүгийн загвар боловсруулж, төслийн мөнгөн урсгалын төсөөлөл, орлогын тайлан бэлтгэнэ. Төслийн онцлогоос хамааран санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээ хийх хугацаа өөр өөр байна. Хөрөнгө оруулалтын төслийн үр ашгийг тооцохдоо мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг заавал харгалзах ба өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV), Ашигт ажиллагааны индекс (PI), хорогдуулсан эргэн төлөгдөх хугацаа (DPP), дотоод өгөөжийн хувь (IRR), зардал үр ашгийн харьцаа (BCR) гэх зэрэг хэд хэдэн үзүүлэлтүүдээр хэмжинэ. Төслийн онцлогоос хамааран эдгээр үзүүлэлтүүдээс 4-ээс доошгүй үзүүлэлтийг сонгон төслийн санхүүгийн үр ашгийг тооцох шаардлагатай. Мөн мэдрэмжийн шинжилгээ, хугарлын цэгийн шинжилгээ гэх мэт санхүүгийн үр ашгийг олон талаас нь харуулах шинжилгээнүүдийг хийх нь зүйтэй.

4.1.8.2. Эдийн засгийн үр ашгийн шинжилгээ

Эдийн засгийн шинжилгээний үе шат нь санхүүгийн шинжилгээний үе шаттай адил боловч зарим зардал, үр ашгийн үнэлгээ, шинжилгээний үзүүлэлтүүд нь өөр байна. Эдийн засгийн зардлыг тодорхойлохдоо санхүүгийн зардал дээр байгаль орчны бохирдол зэрэг төслөөс үзүүлэх сөрөг дам нөлөөний зардлыг нэмж, улсын хэмжээнд нэг этгээдээс нөгөө этгээдэд хийх шилжүүлэг (татвар, хураамж гэх мэт)-ийг зардлаас хасаж тооцно. Санхүүгийн зардлыг үндэслэн эдийн засгийн зардлыг тооцохдоо санхүүгийн зардлыг тохируулах коэффициентээр үржүүлнэ. Тохируулах коэффициентийг ашиглан төслийн санхүүгийн загварын харьцуулах үнээр илэрхийлсэн санхүүгийн мөнгөн урсгалыг эдийн засгийн мөнгөн урсгал болгож өөрчилнө. Төслөөс нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг дам нөлөөг тооцохдоо эдгээр нөлөөг арилгах зардлыг тооцно. Төслийн үр дүн, ажил үйлчилгээг нь шууд хүртэхгүй хэсэгт ямар нэгэн мэдэгдэхүйц үр ашиг өгөх эсхүл тэдгээрээс зардал гарах зэрэг нөлөөлөл байх бол тайлбарлана. Төслөөс нийт эдийн засагт үзүүлэх нэмэлт өгөөж нь бүтээмжийн сайжралт, эрүүл мэндийн эерэг нөлөө, бохирдлын бууралт зэрэг байгаль орчны сөрөг нөлөө багасах зэрэг байж болно. Эдийн засгийн өгөөжийг тоогоор илэрхийлэхдээ төслийн нөлөөний талаар оролцогч талуудтай түлхүү хамтран ажиллаж, өгөөжийн хүрээг ойлгох шаардлагатай. Эдийн засгийн шинжилгээнд "нийгмийн дискаунтын хувь" (SDR), эдийн засгийн өгөөжийн дотоод хувь (EIRR), эдийн засгийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (ENPV) зэргийг ашиглан төслийн эдийн засгийн шинжилгээг хийнэ.

4.1.9. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Төслийг хэрэгжүүлэх болон хэрэгжсэний дараа гарч болох эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тохиолдвол бусдад шилжүүлэх, хохирлыг арилгах зэрэгт чиглэсэн арга хэмжээнүүдийг тодорхойлно.

4.1.9.1. Төслийн эрсдэлийн шинжилгээ

Төслийн төлөвлөлт, бүтээн байгуулалтын болон ашиглалтын үе шат бүрд тохиолдож болох эрсдэлүүд, тэдгээрийн төрөл, хугацаа, давтамж, нөлөөлөх хүчин зүйлс зэргийг тодорхойлж, тэдгээрийн тохиолдох магадлал, түүнээс үүдэн гарах үр дагаврыг тогтоон "Магадлал-үр нөлөө"-ын матрицын аргаар шинжилгээ хийж, эрсдэлийн түвшнийг үнэлнэ.

4.1.9.2. Төслийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө

Эрсдэлт тохиолдол үүсэхээс сэргийлэх, эрсдэлээс үүдэн гарах хохирол, алдагдлыг бууруулах, эрсдэл тохиолдвол бусдад хэрхэн шилжүүлэх (даатгал г.м.) болон учирсан хохирлыг арилгах зэрэг арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна. Эрүүл мэндийн салбар нь онцгой салбар тул гамшгаас сэргийлэх төлөвлөгөө, онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөнүүдийг боловсруулах шаардлагатай.

ТАВ. ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН УРЬДЧИЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

5.1 Төслийн техник эдийн засгийн урьдчилсан судалгааны тайлан дараах нийтлэг бүтэцтэй байна.

I. АГУУЛГЫН ХЭСЭГ

- a. **Нүүр хуудас** - Төслийн нэр, байршил, боловсруулсан хүний нэр, албан тушаал, боловсруулсан огноо
- b. **Агуулга** – Тайлангийн бүтэц дэх бүлэг, хэсгүүдийн жагсаалт, хуудасны дугаарын хамт
- c. **Хүснэгт, зургийн жагсаалт** – Тайланд багтсан бүх хүснэгт, зургийн жагсаалт, хуудасны дугаарын хамт

- d. **Товчилсон үгийн тайлбар** – Тайланд орсон бүх товчилсон үгийн тайлбарыг нэгтгэн оруулна.

II. ТАНИЛЦУУЛГЫН ХЭСЭГ

- a. **ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ** – Энэ хэсэгт уг техник эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийх хэрэгцээ, шаардлага, хууль, эрх зүйн болон бодлогын үндэслэл, гэрээ, ажлын даалгаврын талаарх товч мэдээлэл; судалгаагаар дэвшүүлсэн зорилго, зорилт; судалгаандаа ашигласан арга, аргачлал, арга зүй; судалгааны ажлын хамарсан хүрээ, гүйцэтгэсэн хугацаа; судалгааны ажлын тайлангийн баримт бичгийн бүтэц, агуулгын товч тайлбар; судлаачдын багийн талаар товч танилцуулж бичнэ.
- b. **ТӨСЛИЙН ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА** – Энэ хэсэгт техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг хураангуйлан бүлэг тус бүрээс хамгийн чухал тоон мэдээлэл, ойлголт, голлох хүчин зүйлсийг сонгож авч, төслийг иж бүрэн, бүх талаас нь товч тодорхой танилцуулна. Ингэснээр тухайн төслийн ач холбогдол, үр ашгийг богино хугацаанд бүрэн хэмжээнд мэдэж авах боломжтой болох ба дараах мэдээллүүдийг багтаасан байна. Үүнд: Төслийн нэр, Техник эдийн засгийн үндэслэлийг гүйцэтгэгч, Төсөл хөгжүүлэгч, Төсөл хэрэгжүүлэгч, Төсөл хэрэгжих байршил, Төслийн бүтээн байгуулалтын болон үйл ажиллагааны үе шатуудын үргэлжлэх хугацаа, Төслийн нийгэм, эдийн засгийн үр ашиг, ач холбогдол, Төслийн техник, технологи, нийгэм, байгаль орчин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, Хөрөнгө оруулалтын хэмжээ, зориулалт, орлого, зардал, санхүүгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийн үндсэн үзүүлэлтүүд гэх мэт. Энэ нь төслийн хураангуй танилцуулгын нийтлэг агуулга бөгөөд төслийн онцлогоос хамааран өөр өөр байж болно.

III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

- a. **НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ** – Энэ хэсэгт төсөл хэрэгжих орчин, салбар, дэд салбар, бүс, орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох зорилгоор хийсэн Макро эдийн засгийн өнөөгийн байдлын шинжилгээ, Хүн ам зүйн судалгаа, Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын өнөөгийн байдлын шинжилгээ, Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн өнөөгийн байдлын шинжилгээ, Хууль эрх зүйн орчны шинжилгээ болон бусад судалгаа, шинжилгээнүүдийн танилцуулга, үр дүн, дүгнэлтийг бичнэ.
- b. **ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШИНЖИЛГЭЭ** – Эрэлтийн шинжилгээ, Нийлүүлэлтийн шинжилгээ, Зөрүүгийн (GAP) шинжилгээ болон төслийн эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох зорилгын хүрээнд хийгдсэн бусад судалгаа, шинжилгээнүүдийн танилцуулга, үр дүн, дүгнэлтийг бичнэ.

IV. ТӨСЛИЙН ҮНДСЭН ХЭСЭГ

- a. **ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ** – Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, үндэслэл, Төслийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, Төслийн амжилтын хүчин зүйлс, нийгэм, эдийн засгийн үр нөлөө зэргийг тодорхой бичнэ.
- b. **ТӨСЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ** - Энэ хэсэгт төслийн хүрээнд санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхойлолт, Техник, технологийн шийдлийн талаар тодорхой оруулсан байна. Мөн төслийн онцлогоос хамааран хийгдэх бусад төлөвлөлт, шийдлүүдийг багтаасан байна.
- c. **БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ** - Архитектур төлөвлөлтийн шийдэл, Дэд бүтцийн төлөвлөлт болон бусад гэсэн хоёр дэд бүлэгтэйгээр бичигдэнэ. Энэ хэсэгт төслийн онцлогоос хамааран нэр дурдсанаас өөр бусад төлөвлөлт, шийдлүүд хийгдсэн бол тэдгээрийн үр дүнг танилцуулна.
- d. **ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ** - Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн төлөвлөлт, Хэрэгжүүлэх арга хэмжээний

төлөвлөлтүүд болон тухайн төслийн онцлогоос хамааран хийгдсэн бусад төлөвлөлтүүдийг энд тусгана.

- e. **ТӨСЛИЙН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО** - Төслийн анхны хөрөнгө оруулалтын тооцоо, Санхүүжилтийн эх үүсвэр, хуваарь, Төслийн санхүүгийн тооцооллыг энэ хэсэг тайлбарлан оруулсан байна.
- f. **ТӨСЛИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ** - Санхүү, хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ, Эдийн засгийн үр ашгийн шинжилгээ гэсэн хоёр хэсэгтэйгээр бичигдэнэ.
- g. **ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ** - Төслийн эрсдэлийн шинжилгээ, түүний танилцуулга, үр дүн, дүгнэлт, Төслийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг энд бичнэ.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ – Энэ хэсэгт төслийн техник эдийн засгийн урьдчилсан судалгааны үр дүн, төсөл хэрэгжих боломжтой эсэх талаарх дүгнэлт, цаашид уг төслийг нарийвчлан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах шаардлагатай эсэх, хэрэв тийм бол түүнд тавигдах шаардлага, нарийвчлан хийгдэх судалгаа, шинжилгээнүүдийн санал зэргийг багтаасан байна.

VI. ХАВСРАЛТ - Судалгааны ажилтай холбогдох хавсралт материалуудыг тусгана.

---oO---